



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 02 сарын 31 өдөр

Дугаар 01/45

Жавхлант

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, “Байгаль орчныг хамгаалах тухай хууль”-ийн 17 дугаар зүйлийн 17.1.1. Засгийн газрын 2022 оны 02-р тогтоол “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 3.6.4 дэх заалт, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 3 дугаар хуралдааны А/19 дугаар тогтоолын 05 дугаар хавсралт /байгалийн нөөц ашигласан орлогоос санхүүжүүлэх төсвийн жагсаалтын 3.4 дэх хэсэг/-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сүмбэр багт монгол тарвага сэргээн нутагшуулах “Амьтны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх ажлын гэрээ багц-1”, Наран багт монгол тарвага сэргээн нутагшуулах “Амьтны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх ажлын гэрээ багц-2” тус тус гэрээний дагуу урьдчилгаа 30 хувь, нийт 12 000 000 (арван хоёр сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Р.Оюунчимэг)-т даалгасугай.

3. Зарцуулагдах 12 000 000 (арван хоёр сая) төгрөгийг байгалийн нөөц ашигласан орлогоос 2025 онд санхүүжүүлэх төсвөөс гаргахыг нягтлан бодогч (С.Наранцэцэг)-д зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Энхзаяа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.БАТЧУЛУУН